

ХУУЛЬ ЁСООР ӨВЛӨХ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES REGARDING THE RIGHTS OF INHERITANCE IN THE CURRENT LEGISLATION

**Б.ЖАРГАЛСАЙХАН**

"Их Засаг" олон улсын их сургуулийн багш

JARGALSAIKHAN B

Lecturer at "Ikh Zasag" International University

Товч агуулга: Өвлөх эрх зүй буюу өв залгамжлалын эрх зүйг Монгол Улсын үндсэн хуульд зааснаас үзэхэд "... Монгол Улсын иргэн өв залгамжлалын эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ" хэмээн ерөнхийлөн хуульчлан тогтоосон. Өвлөх эрхийн асуудал нь иргэний эрх зүйн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болохдоо өмчийн эрхэд хамааруулан системчлэгдсэн байдаг. Өмчийн эрхэд иргэн зохих ёсоор хууль зүйн дагуу олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, өв хөрөнгөө бусдад залгамжлуулах тухай асуудлуудыг хамруулан үздэг. Энэхүү өгүүлээр өв залгамжлалын эрх зүй нь иргэний эрх зүйн системд өөрийн онцлог, шинж байдлаар оршдог гэдгийг нээн илрүүлж, түүний үндэслэлийг тодорхойлж үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдлээ.

Abstract: If we look at how the rights of inheritance have been reflected in the Constitution of Mongolia we will clearly see that it has been only generally defined; as it is stated that "Mongolian citizens will be assured the rights of inheritance". The rights of inheritance as a key component of civil law are also systemized to be a part of property rights. The legislation on property rights includes the rights to fair acquisition, possession, use and inheritance of property to others. This article is aimed at the identifying the unique features of inheritance rights as belonging to civil law and improving the legal basis for regulating the rights of inheritance.

Түлхүүр үгс: Хууль ёсоор өвлөх эрх, өв залгамжлал, өв нээгдэх, өвлөх шатлал.

Keywords: Rights to inheritance, inheritance, probate, inheritance process.

Өвлөх эрхийн үүсэл нь эртний Ром улсаас үүсэлтэй бөгөөд МЭӨ V зуунд үүссэн гэж үздэг. Ромын хуульч Гайгийн ангилснаар "...

Өв залгамжлалын эрх зүй нь юмсын тухай сургаалын салшгүй хэсэг, өөрөөр хэлбэл эд юмс олж авах арга юм"¹. Ф.Энгельсийн тэмдэглэснээр "...Эртний бүр эхэн үед омгийн гишүүд нь харилцан өв залгамжлах эрхтэй ба өв хөрөнгө нь омгийнхоо дотроо үлдэж байжээ. Эхний үед Ромд эцгийн эрхт үе нэгэнт ноёрхож байсан учраас эмэгтэй талын удам өв залгамжилдаггүй байжээ"². Өв залгамжлалын асуудалд эртний Ромчууд язгуурын зан заншил гэж ойлгож эртнээс хүндэтгэн уламжилж удаан хугацаанд хадгалан агуулгыг нь өөрчлөхгүй явж ирсэн байдаг. 12 таблицын хууль гарснаар бие даасан салбар эрх зүй болж хөгжсөн гэж үздэг³ байна. Харин Монголчууд эрт дээр үеэс хууль цаазын уламжлалтай бөгөөд өвлөх эрх зүйн харилцааг зохицуулж ирсэн түүхэн эх сурвалжууд байдаг. Монголын нууц товчоо болон түүхэн хуулиудад өмч, өв хуваах, өв залгамжлуулах тухай заасны гэрч бол "Алунгуаг нас барсны дараа түүний хөвүүд Билгүүтэй, Билгүүнүүтэй, Буха хатаги, Бухату салжи нар адуу, малаа хуваан авсан бөгөөд дүү Бодончар мунхагт хувь өгөөгүй тухай мэдээ байдаг"⁴. Үүнээс хойш тухайлбал: Их Засаг хуульд "...нас барсан хүний өв хөрөнгийг хууль ёсоор залгамжлах эрх бүхий хүнээс өөр хүн уг эрхийг эдэлж болохгүй тухай хуулиар хориглосон байдаг. Хэрэв нас барагсдыг өв залгамжлах үр хүүхэд байхгүй бол эд хөрөнгийн талыг нь түүний шавьд болон зарцад нь өгч болно. Харин уг өмч хөрөнгийн улсын санд үл оруулж болно хэмээн"заасан байдаг. Мөн

¹ Б.Минжүүрдорж. УБЭСДС. Ромын эрх зүй. УБ., 2004.

² Ф.Энгельс. Эрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл түүвэр зохиол. III боть. УБ., 1979. 341-342 дахь тал

³ Д.Баярсайхан. Ромын эрх зүй 2 дах хэвлэл, УБ., 2000. 139 дэх тал

⁴ Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд. Монгол хууль. УБ., 1997. 12 дахь тал.



ХУУЛЬ
САХИУЛАХУЙ



Юан гүрний нэвтэрхий толь, Монгол ойрдын хууль, Арван буянт номын цагаан түүх, Халх журам зэрэг түүхэн хуулиудад уг эрх зүйн харилцааг зохицуулж байсан арвин түүхтэй билээ.

Өвлөх эрх зүй буюу өв залгамжлалын эрх зүйг судлаачид дор бүрнээ өөрсдийн ойлгоцоор дүгнэсэн байдаг. Тухайлбал доктор, профессор Д.Баярсайхан "...Өв залгамжлалын эрх зүйн бие даасан нэг институт болж хөгжсөн хэдий ч түүний анхны гарал нь гэр бүлийн үүслээс эх үндэстэй юм"⁵. Харин өв залгамжлал гэдэг нь "...эрх зүйн этгээд нас барснаар тухайн этгээдийн өмчлөлийн хувь заяаг шийдэхтэй холбогдсон хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн харилцаа бөгөөд энэхүү харилцааны агуулга нь өвлүүлэгч, өвлөгчийн эрх, үүргийн хамаарлаар тодорхойлогдоно"⁶ гэжээ. Мөн судлаач Я.Цэвэлмаа тайлбарласнаас үзэхэд "... эзэмшиж байсан хүнийг нас барахад нь өөр хүнд шилжиж очих хөрөнгө"⁷ нь өв залгамжлал юм. Гэх мэтчилэн тодорхойлсон байдаг. Өвлөх эрх зүйн харилцааны хувьд "... төрөөс тогтоосон буюу зөвшөөрсөн өв залгамжлалын хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн тодорхой төрлийн" харилцааг ойлгодог. Энэхүү харилцаанд өвлөгч, өвлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдүүд байна. Өвлүүлэгч нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хэн ч байж болох ба гагцхүү өвлүүлэх эд хөрөнгийн өмчлөгч эзэн нь байх учиртай. Харин хуулийн этгээдийн хувьд эрх залгамжлагдах асуудал яригдахаас өв залгамжлал яригдахгүй. Харин үүнийг нөгөө талаас төр, хуулийн этгээд нь иргэний эрх зүйн субъект болохын хувьд өв залгамжлуулах асуудал онолын хувьд байж болохыг үгүйсгэх аргагүй юм. 2002 оны иргэний хуульд өвлөх эрхээ алдах тухай тусгайлан заасан нь байдаг. Харин өвлүүлэгчийн хувийн өмчийн эрхэд хамаарах эд хөрөнгө нь уг харилцааны объект байна. МУ-ын иргэний хуульд зааснаар "... Өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө" гэж заасан нь уг харилцааны объектыг тодорхойлсон хэрэг юм. Өв залгамжлалын эрх зүйн харилцааны агуулга нь уг эрх зүйн харилцаанд оролцогч буюу өвлүүлэгч, өвлөгчийн болон бусад этгээдүүдийн эдлэх эрх, хүлээх үүргээр тодорхойлогдоно. Өвлөх эрх зүйн харилцааны агуулгыг ерөнхий

байдлаар энгийн болон нийлмэл агуулгатай гэж хувааж болох бөгөөд, энгийн гэдэг нь талуудын аль нэг нь эрх эдэлж нөгөө нь үүрэг хүлээж байгааг, харин нийлмэл агуулгатай гэдэг нь талууд харилцан эрх эдэлж байгаагаар тодорхойлогдоно. Тухайлбал: МУ-ын иргэний хуульд "... Төр буюу хуулийн этгээдэд гэрээслэгч нь түүний зориулалтыг зааж болно" мөн "...гэрээслэгч хууль ёсны бусад өөр өөр этгээдэд, эсхүл нийтийн тусын тулд гэрээслэлээр өвлөгчид аливаа үүрэг хүлээлгэх эрхтэй" гэсэн нь энгийн хэлбэрийн жишээ юм. Харин уг харилцааны фактын тухайд эрх зүйн онол ёсоор өвлөх эрх зүйн харилцаа үүсэж, өөрчлөгдөх, дуусгавар болохыг хэлнэ. Өв залгамжлалын эрх зүйн харилцаа өвлүүлэгч нас барсан болон нас барсан гэж зарлагдсан үеэс үүсэх бөгөөд үүнийг хуульд зааснаар "өв нээгдэх" гэнэ.

Монгол Улсад хийгээд дэлхийн ихэнх улс орнуудад Өв залгамжлалыг:

1. Хууль ёсоор өвлөх;
2. Гэрээслэлээр өвлөх гэж хоёр ангилдаг.

Хууль ёсоор өвлөгчийн тухайд: хуулиар тусгайлан нарийвчлан шатлан зохицуулсан байдаг. Тухайлбал:

Нэгдүгээр ээлжид: Нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчлэн авсан, түүнийг нас барсан хойн төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчлэгчийн эцэг, эх;

Хоёрдугаар ээлжид: Дээр дурдсан өвлөгчид байхгүй эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан бусад этгээд өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ өвлөнө.

Гуравдугаар ээлжид: Дээр дурдагдсан өвлөгчид байхгүй эсхүл тэдгээр нь өв хүлээн авахаас татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол өвлүүлэгчийн ачинцар, зээнцэр нь эцэг, эхдээ хуульд зааснаар өвлөгдвөл зохих байсан эд хөрөнгийн хэсгийг хуваан өвлөнө. Энэхүү шатлалуудад дурдсан өвлөгчид нь бүгд нэгэн зэрэг өвлөхгүй бөгөөд өвлүүлэгч этгээд дээрх өвлөгчдийн аль нэгэнд (жишээ нь ачинцарт) нь нэр заан гэрээсэлсэн тохиолдолд бусдаас түрүүлж буюу заавал шатлалыг хүлээх шаардлагагүйгээр өвлөх эрхтэйг хуульчилжээ. Мөн нэгээс доошгүй жилийн хугацаанд түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн хууль ёсны өвлөгчид тооцогдох бөгөөд өөр өвлөгч байвал энэхүү асрамжид байсан этгээд нь тэдгээртэй адил хэмжээгээр өвлөнө. Хууль ёсоор өвлөхөд "... гэрийн эд хогшил нь ээлж дараалал эд хөрөнгийн өвлөгдөх шинж

⁵ Т.Мөнхжаргал. МУИС-ХЗС. Монгол Улсын иргэний эрх зүй (ерөнхий анги). УБ., 2003. 116 дахь тал.

⁶ Д.Баярсайхан. Ромын эрх зүй. УБ., 2000. 118 дэх тал.

⁷ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ., 2000. 428 дахь тал.

байдлаас үл шалтгаалан өвлүүлэгчийг нас барах үед түүнтэй хамт амьдарч байсан хууль ёсны өвлөгчид шилжинэ” харин гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгө дээрх байдлын нэгэн адил өвлөгдөнө.

Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн гишүүнд оногдох хэсгийг нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчлэн авсан түүнийг нас барсан хойн төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх биет байдлаар болон мөнгөн хэлбэрээр өвлөх эрхтэй. Гэрээслээгүй үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өвлөгчид адил тэнцүү хэмжээгээр өвлөх эрхтэй байхаар хуульчилсан. Хэрэв хууль ёсны гэрээслэлээр өвлөгч нь өв нээгдсэний дараа уг өвийг хүлээн авч чадалгүй нас барсан бол өвлөгдөх эд хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгийг хүлээн авах эрх түүний өвлөгчид шилжинэ. Ийнхүү шилжсэн эрх нь өв хүлээн авах хугацааны дотор буюу нийтлэг журмын дагуу хэрэгжинэ. Өвлөгч өвлөгдөх эд хөрөнгийг бусад өвлөгчийн ирэхийг хүлээхгүйгээр авч болох боловч өв нээгдсэн өдрөөс хойш 1 жил өнгөрөөгүй буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүртэл уг эд хөрөнгийг худалдах, бэлэглэх буюу барьцаалах, гэрээслэх эрхгүй. Бусад өв залгамжлагчдыг ирэхээс өмнө өвлөсөн этгээд нь тухайн эд хөрөнгөнөөс дараах зардлыг гаргуулах эрхтэй. Үүнд:

1. Өвлүүлэгчийн өвчтэй байхад асрах болон түүнийг оршуулахад гарсан зардал.
2. Өвлүүлэгчийн асрамжид байсан бусад өвлүүлэгчээс тэтгэмж авах эрхтэй этгээдийг тэтгэсний зардал.
3. Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах бусад төлбөрийн шаардлагыг хангах зардал.
4. Өвлөгдсөн эд хөрөнгийг хамгаалахад гарсан зардал. Үүнийг аймаг, нийслэл, сум багийн засаг дарга нар хэрэгжүүлнэ.

Хууль ёсны өвлөгчид өвлөх эрхийн гэрчилгээг өв нээгдсэнээс хойш 1 жил өнгөрсний дараа олгоно. Энэ нь өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалж буй нэгэн хэлбэр юм. МУ-ын цагдаагийн байгууллагын тухай хууль тогтоомжид заасны дагуу цагдаагийн байгууллагын захиргааны үүрэгт “өв залгамжлалын эд хөрөнгийн бүртгэлийн дугаар олгож улсын хэмжээгээр нэгтгэн хөтлөх” гэж заасны дагуу өв залгамжилсан эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх мэдүүлгийг хүлээн авснаас хойш 7 хонгийн дотор яаралтай хөлс төлсөн бол ажлын 8 цагийн дотор бүртгэх эсэхийг шийднэ.

Өв залгамжлах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ.

1. Өв залгамжлах эрхийн гэрчилгээ
2. Эд хөрөнгийн өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн улсын гэрчилгээ
3. Өв залгамжлагчийн иргэний үнэмлэхийн хуулбар болон тухайн өв залгамжлагчаас өөр өв залгамжлагч байхгүйн лавтай баримтаар нотлогдвол гэрчилгээг өв нээгдсэнээс нэг жилийн дараа олгож болно. Ийнхүү өлөх эрхийн гэрчилгээ авах нь өвлөгчийн эрх юм. Өвлөх эрхийн гэрчилгээ нь эрх олгож байгаа хууль зүйн ач холбогдол бүхий үйл явдал мөн.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Өвлөх эрхийн зохицуулалт нь манай улсад хоцрогдож буй салбарын нэг юм. Монгол Улсын анхны 1924 оны иргэний хуульд өвлөх эрхийн зохицуулалт батлагдсанаас хойш дорвитой өөрчлөлт ороогүй гэж хэлэхэд болно.

Монгол Улсын иргэний хууль дахь системчлэлийн хувьд: Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бие даасан болон 2002 оны Монгол Улсын иргэний хууль зургаан үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд түүний тавдугаар хэсэгт “өвлөх” хэмээн бүхэл бүтэн хэсэг болгон зохицуулсан нь түүний иргэний эрх зүйн системд томоохон байр, суурийг эзэлж байгааг илэрхийлэх нэг үндэслэл юм. Гэтэл өмчийн эрх зүйн хэсэг гэж үзэх бөгөөд хэрэг дээрээ Өмчийн харилцааг иргэний хуулийн нэгдүгээр хэсгийн 5-р дэд хэсгийн 12 дугаар бүлгээр зохицуулсан нь сонирхолтой. Иргэний хуульд зааснаар өвлөх эрхийн асуудлыг үүргийн эрх, гэрээний эрх, гэрээний бус үүргийн дараа байрлуулбал дэс дараа нь тохирч байгаа юм. Өвлөх эрхийн асуудал нь эд баялгийн эрх, эд баялгийн бус эрхийн аль алинтай нь шууд хамааралтай юм. Уг харилцаатай холбоотой дараах санал байна. Үүнд:

1. Өвлөх эрх зүйн зохицуулалт дахь хууль ёсоор өвлөгчдийн өвлөлийн гурван шатлалын дараах үе буюу 4, 5 дугаар шатлалыг хуульчлан тогтоож өгөх шаардлагатай. Үүний ач холбогдол нь аливаа этгээд өвлөлийн аль шатлалд хамаарч байгааг байгааг мэдэхээс гадна, иргэн хүн өвлөлийн асуудлаар өөрийгөө өмгөөлөн оролцох өргөн эрхийг эдлүүлэх ач холбогдолтой юм. Мөн өнөө үед Монголчуудын наслалт уртассан болон эрт төрөлттэй холбоотойгоор 4 болон 5 дахь үеэ



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ

үзэх тохиолдол гарч байгааг харгалзан үзэх хэрэгтэй гэж ойлгож байна.

2. Мөн зах зээлийн эдийн засгийн харилцаанд орж, иргэдэд эх орны хишиг 1072 ширхэг хувьцааг тараасан боловч уг хувьцааг хэрхэн өвлүүлэх талаарх зохицуулалт одоог хэр нь байхгүй байна.

3. Газар өвлүүлэх тухай асуудлыг одоо хэр нь хуульчлан тусгаагүй байна. Газрыг үл хөдлөх эд хөрөнгө гэсэн агуулгаар авч үзэн зохицуулж байна. Гэтэл газар нь сонгодог үл хөдлөх эд хөрөнгө гэсэн утгаараа Германы иргэний хуулийн 2113, 2114, 2165, 2166, 2167, 2168-р зүйлүүдэд барьцаанд байгаа өмчлөлийн газраа өвлүүлэхтэй холбогдсон чухал асуудлыг зохицуулжээ. Мөн Оросын Холбооны Улсын иргэний хуулийн 1181-р зүйлд: Газар өмчлөх эрх нь өвийн эрхийн бүрэлдэхүүнд орох бөгөөд иргэний хуульд заасан ерөнхий журмаар өвлөгдөнө. 1182-р зүйлд: Газар өмчлөх эрхийг хуваарилан өдлөхийг зөвшөөрсөн бөгөөд ийм боломжгүй бол давуу эрхтэй өвлөгчид дангаар өвлүүлнэ. Энэ тохиолдолд бусад өвлөгчдөд нөхөн төлбөрийг өөр эд хөрөнгөөр олгох буюу мөнгөөр төлж болно. Давуу эрхтэй өвлөгч гэж уг газар дээр өвлүүлэгчийн хамт аж ахуй эрхэлж, ам зуулгаа залгуулж аж төрж байгаа этгээдийг ойлгоно. Энэхүү зохицуулалт манайд байж болохоор зохицуулалт мэт санагдана.

4. Мөн өвлүүлэгчийг, эсхүл хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгчийг санаатайгаар алсан, түүнчлэн тэдгээрийн аль нэгний нас барах шалтгаан болсон бусад гэмт хэргийг санаатай үйлдсэн нь шүүхийн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол гэм буруутай этгээд өвлөх эрхээ алдах тухай Монгол Улсын иргэний хуульд заасан. Гэтэл Герман улсын иргэний хуулийн 517-р зүйлд дээрхээс гадна, өвлүүлэгчийг нас барахаас өмнө гэрээслэл бичих, эсхүл гэрээслэлээ өөрчлөх байдалд хууль бусаар санаатайгаар хүргэсэн, эсхүл залилан мэхлэх буюу аюул учруулахаар заналхийлж гэрээслэл бичүүлсэн буюу гэрээслэлийг өөрчлүүлсэн бол өвлөгч өвлөх эрхээ алдаж гэж заажээ. Үүнийг мөн хуульд тусгайлан тусгаж болмоор санаа юм.

5. Үнэт цаас өвлүүлэх тухай зохицуулалт өнөөг хэр нь байхгүй байгааг анхаарах хэрэгтэй байна.

6. Мөн өнөөдөр практик дахь нэг дэвшүүлэх ёстой асуудал бол "бутаг" хүүхдийн тухай асуудал юм. Энэхүү асуудал нь хөдөө орон нутаг нэн ялангуяа элбэг

тохиолдох бөгөөд бутаг хүүхдийн өвлөх эрхийн асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлага тулгарч байна. Энэ нь хүүхдийн эрхийг хамгаалахад нэн шаардлагатай эерэг зохицуулалт байхыг үгүйсгэхгүй юм.

1. Энд өвлөх эрхийг цаашид хөгжүүлэх, боловсронгуй болгоход хэрэгтэй зарим нэг санааг дурдлаа. Нарийвчлан судалж үзвэл байж болмоор санаанууд гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Т.Мөнхжаргал. МУИС-ХЗС. Монгол Улсын иргэний эрх зүй (Ерөнхий анги). УБ., 2003.
2. Д.Баярсайхан. Ромын эрх зүй. УБ., 2000.
3. Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ., 2000.
4. Б.Минжүүрдорж. УБЭСДС. Ромын эрх зүй. УБ., 2004.
5. Ф.Энгельс. Эрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл түүвэр зохиол. III боть. УБ., 1979.
6. Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд. Монгол хууль. УБ., 1997.
7. О. Жамбалдорж. Монгол Улсын иргэний эрх зүй (Ерөнхий анги). УБ., 2004.
8. Монгол Улсын иргэний хууль. 2002.
9. Германское Гражданское уложение (Bürgerliches Gesetzbuch) 1991.
10. Гражданский Кодекс Российской Федерации. М., 2002.
11. О.Жамбалдорж, Ж.Амарсайхан, Ж.Ариунзаяа. Монгол Улсын иргэний эрх зүй II дэвтэр. УБ., 2006.